**НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХМАД НАСТАН, БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХАРИУЦСАН АЖИЛТАН Д.АМАРЗАЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. "АХМАД НАСТАНД ЭЭЛТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | 1.1.1."Ач санах" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь 80% | Хэрэгжилтийн хувь 90% | Ахмад настны Ач санах хөтөлбөр нь 3 зорилтын хүрээнд 20 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2024 онд хөтөлбөрийн хүрээнд: Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Зэвсэгт хүчний 103 жил, Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан хүндэтгэлийн арга хэмжээ, "Эх үрийн элбэрэл" тоглолт, Ахмадын баяраар "Ахмадууд дуулж байна" урлагийн наадам, Хойд бүсийг/ Ахмад настны тухай хуулийг сурталчлан таниулах сэдэвт сургалт, орон нутгийн аялал, аймгийн аварга шалгаруулах волейбол, софт волейбол, үүргэвчтэй аялал тэмцээн, мөн сар бүрийн 15-нд ахмадын "Дуулах өдөр" дуун цэнгүүн, ахмад настанд чиглэсэн 23 удаагийн сургалтын үйл ажиллагаа зэрэг арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 14000 гаруй ахмад хамрагдсан байна.<br>Орхон аймгийн ХХҮГ, Улаан загалмайн хороо хамтран Жаргалант сумын 50 ахмад, Баян-Өндөр сумын 100 ахмад настныг өдрийн үйлчилгээнд хамруулсан. Сар шинийн баярыг тохиолдуулан 3350 ахмадуудад Засаг | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даргын хүндэтгэл үзүүлж, зуны саам амралтад 250 ахмадыг амрах нөхцөлөөр хангаж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хөтөлбөр 100 хувийн хэрэгжилттэй байна. | | |
| 2. | 1.1.2."Анхдагч " хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь 80% | Хэрэгжилтийн хувь 90% | Анхдагч дэд хөтөлбөр нь 3 зорилт 10 үндсэн үйл ажиллагааг ажиллгагааг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд МАНЗ-Баатар холбоо, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо, Барилгачин дайчдын холбоо, Залуу насаа эргэн дурсахуй холбооны гишүүдийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 29.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Тус дэмжлэгийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч буй 23 анхдагчид тусламж, хэвтрийн өвчтэй 65 анхдагчид гэрийн эргэлт, ахмадын сувилалд 86, өдөр өнжүүлэх үйл ажиллагаанд 41 анхдагч тус тус хамрагдсан. Мөн илгээлтийн эздийн 50 жилийн ойн баярыг аймгийн баяр наадамтай хамтатган тэмдэглэн өнгөрүүлж нийт 2200 гаруй анхдагч илгээлтийн эзэд, хамрагдсан. 2.3 тэрбум төгрөгийн урамшуулал олгож, 3000 анхдагч ахмадыг 50 жилийн ойн медалиар шагнасан. Тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг 3, сургалтын үйл ажиллагаа 2, туршлага судлах уулзалт аялал 5, спортын урлагийн 3 төрөлт тэмцээн Эрдэнэт хотын өдөр, анхдагчийн өдөр зэргийг зохион байгуулж даврадсан тоогоор 2200 гаруй | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |

80

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | анхдагч, ахмадууд хамрагдсан байна. Хөтөлбөр 100 хувийн хэрэгжилттэй байна. | | |
| ХОЁР. "НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫГ ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ЗӨВ ХЭВ МАЯГ, АЖ ТӨРӨХ ЁСНЫ САЛШГҮЙ ХЭСЭГ БОЛГОЖ, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ ЭЭЛТЭЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | 1.2.1. Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, тэмцээн уралдаанд амжилттай оролцуулах | Хамрагдах тамирчдын тоо | Тамирчдын тоо 182 байна. | Тамирчдын тоо 196-д хүрсэн байна. | Тайлант онд өсвөрийн шигшээ 16 багт тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлж, 196 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалтаа тогтмол хийж байна. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 13 төрлөөр зохион байгуулж, нийт 2152 тамирчдыг хамруулсан. Өсвөр үеийн тамирчид олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд 167 өсвөрийн тамирчид медаль авсан амжилтыг үзүүлснээс 68 алт, 42 мөнгө, 57 хүрэл медалийг хүртсэн. Тэмцээн уралдааны зардалд орон нутгийн төсвийн 40,0 сая төгрөг зарцуулсан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| 2 | 1.2.2. Улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээнийг орон нутагт зохион байгуулах | Зохион байгуулагдсан тэмцээний тоо | Зохион байгуулагдсан тэмцээний тоо 5 | Зохион байгуулагдсан тэмцээний тоо 6 | Орон нутагтаа улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг зохион байгуулах ажлын хүрээнд улсын аварга шалгаруулах тэмцээн 9, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 тус тус зохион байгуулж, нийт 4162 тамирчин оролцсон. Тэмцээн уралдаан зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 124,7 сая төгрөг зарцуулж, худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагад 450,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| 3 | 1.2.3. Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж, "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяныг аймгийн иргэд | 8000 иргэнийг хамруулсан байна. | Бэлтгэл ажил хангагдсан байна. | 8000 иргэнийг хамруулсан байна. | "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аянд 2021 онд 15954, 2022 онд 44,856 иргэн тус тус хамрагдсан. 2023 онд 15,229 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан. | 2024.01.01<br>2024.12.31 | 92,5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон ААНБ-уудын дунд өрнүүлэх | | | | Тайлант онд "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 24,650 мянган иргэнийг хамруулсан. Тус арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 15,0 сая төгрөг зарцуулсан.<br>Ингэснээр иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийг нэмэгдүүлсэн. | | |
| 4 | 1.2.4. Үндэсний болон багийн спортын төрлүүдээр иргэдийн спортын их наадмыг шат дараатай зохион байгуулах | Зохион байгуулагд | Зохион байгуулагдсан байна. | Зохион байгуулагдсан байна. | Үндэсний болон багийн спортын төрлүүдээр "Иргэдийн спортын наадам"-ыг 2021 онд спортын 3 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, олс таталт) зохион байгуулж, 900 иргэн хамруулсан бол 2022 онд спортын 6 төрлөөр зохион байгуулж 897 иргэнийг хамруулж, 12.8 сая төгрөг зарцуулсан.<br>2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран "Иргэдийн спортын наадам"-ыг үндэсний болон багийн спортын 8 төрлөөр зохион байгуулж сагсан бөмбөгийн төрөлд 308, волейболын төрөлд 384, олс таталтын төрөлд 184, ширээний теннисний төрөлд 46, үндэсний бөхийн төрөлд 69, буудлагын төрөлд 92, дартсын төрөлд 46, Мас-рестлинг /Модон барилдаан/-ны төрөлд 32 иргэн тус тус оролцож нийт 1143 иргэн хамрагдсан. Тэмцээний үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулсан.<br><br>Тайланд онд "Иргэдийн спортын наадам"-ыг багийн болон үндэсний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сан тэмцээний тоо | | | спортын 8 төрлөөр зохион байгуулж, 1015 иргэн оролцсон. Тэмцээн зохион байгуулахад орон нутгийн төсвийн 25,0 сая төгрөгийг зарцуулсан. | | |
| ГУРАВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 6 | 1.3.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | Биелэлтийг хагас жилийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | Биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж 2024 оны 1-р сард батлуулсан. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| 7 | 1.3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй байх | Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх | Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх | Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн дагуу шаардлагатай, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| 8 | 1.3.3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн | Шийдвэрлэсэн өргөдөл | Өргөдөл гомдлыг шуурхай | Өргөдөл гомдлыг шуурхай | Иргэдээс ирүүлсэн 27 өргөдөл, байгууллагууд спорт холбоодоос ирүүлсэн 95 хүсэлтийг шийдвэрлэж | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |

83

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | хугацаанд шуурхай шийдвэрлэх | гомдлын тоо | шийдвэрлэж хариуг өгсөн байх | шийдвэрлэж хариуг өгсөн байх | холбогдох арга хэмжээг авч буцаан хариу өгсөн. | | |
| 9 | 1.3.4. Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх | Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо | - | Шийдвэрийн дагуу ажиллах | Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын шуурхай хурлаас ирүүлсэн 13 удаагийн үүрэг даалгаварыг биелүүлж, хариуг хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| 10 | 1.3.5. ТАХ-ын спорт заалны үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай асуудлыг удирдлагад танилцуулан шийдвэрлэх | Үйл ажиллагаа хэвийн үргэлжилэх | Шийдвэрийн дагуу ажиллах | Шийдвэрийн дагуу ажиллах | Спорт заал 2024 оны батлагдсан хуваарийн дагуу үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Нийт 23 байгууллага 7 хоног бүр спорт зааланд хичээллэж байа. Мөн Билэгт-Өргөө сургууль болон воллейболын 3 дугуйлан тогтмол хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Спорт заалны гэрэлтүүлэгийг Анд энерги ХХК-тай хамтран солих ажил хийгдэж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/Д | Үүрэг даалгавар<br>(арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Сар шинийн хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад анхаарах | Арга хэмжээг зохион байгуулах | - | Үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна. | Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн Сар шинийн баярыг тохиолдуулан Орхон аймагт амьдарч буй 70 ба түүнээс түүнээс дээш насны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг аймгийн ИТХ-ын төлөөлөлгч нартай хамтран зохион байгууллаа.70-89 настай ахмад настны хүндэтгэлд зориулсан бэлэн мөнгийг Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ-т шилжүүлж иргэдийн дансанд | 2024.01.10<br>2024.02.10 | 100 |

48

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шилжүүлсэн. Цаг тооны бичгийг багуудын ажлын албаар дамжуулан хүргүүлсэн. 90-94 настай ахмад настны хүндэтгэлийн зүйлийг аймгийн ИТХ-ын ажлын албаар, 95 дээш настай ахмад настнуудын хүндэтгэлийг ЗДТГ-ын дарга нар болон аймгийн удирдлагуудаар дамжуулан иргэдэд хүргүүлэх ажил хийгдсэн | | |
| 2. | “Эрдэнэт хотын өдөр болон Анхдагч илгээлтийн эздийн өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулахад анхаарч ажиллах | Арга хэмжээг зохион байгуулах | - | Үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна. | “Эрдэнэт хотын өдөр болон Анхдагч илгээлтийн эздийн өдөр”-ийн арга хэмжээний хүрээнд:<br>12 дугаар сарын 05-ны өдөр Анхдагчдын холбоодын аварга шалгаруулах 3 төрөлт тэмцээн<br>- 12 дугаар сарын 09-ний өдөр Урлагийн бага наадам зохион байгуулах<br>- 12 дугаар сарын 05-11-ний өдрүүдэд Хэвтрийн өвчтэй ахмадуудад гэрийн эргэлт зэрэг үйл ажиллагааг аймгийн Ахмадын хороо, анхдагчдын 6 холбоотой хамтран зохион байгууллаа. 12 сарын 11-ний өдөр баярын хурлыг үйл ажиллагааг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолбортой хамтран зохион байгуулсан. Мөн Баян-Өндөр, Жаргалант сумд, анхдагчдийн төрийн бус байгууллагуудын хэвтрийн өвчтэй 200 ахмад настан хүндэтгэл үзүүлж гэр эргэлт зохион байгуулсан. | 2024.12.05<br>2024.12.11 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| **Д/Д** | **Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Шалгуур үзүүлэлт** | **Гүйцэтгэлийн түвшин** | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Суурь түвшин** | **Хүрэх түвшин** | **Хүрсэн түвшин (биелэлт)** | **Эхэлсэн, дууссан хугацаа** | **Биелэлтийн хувь** |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 2.1.1. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах | Сургалтанд хамрагдсан байна. | - | | Хэрэгжүүлж буй хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрүүдийг чиглэл болгон ажиллаж байна.<br>-Төрийн албаны Зөвлөлөөс төрийн албан хаагчийн гүйцэтгэл үр дүн, төрийн байгуулагуудын бүтээмжийг дэмжих сургалтууд,<br>-Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтанд тус тус хамрагдсан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХМАД НАСТАН, БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ХАРИУЦСАН АЖИЛТАН Д.АМАРЗАЯА